



XII/2025


Тархаасан: 2025 оны 1 дүгээр сарын 15



Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 4 695.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1 044.7 (28.6%) тэрбум төгрөгөөр өслөө.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2024 оны жилийн эцэст 5 573.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1 255.8 (29.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 1 131.7 (30.9%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 82.1 (27.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА*, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар




* Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2024 оны жилийн эцэст 5 419.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1 354.6 (33.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 994.1 (27.0%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зарлага 293.3 (6.3 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Тэтгэврийн даатгалын сангаас 2024 оны жилийн эцэст 509.5 мянган хүнд 4 695.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчид 12.5 (2.5%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 1 044.7 (28.6%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД*, төрлөөр, жилийн эцсийн байдлаар




* Урьдчилсан гүйцэтгэл
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 51.4 мянган хүнд 188.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 9.4 (15.5%) мянган хүнээр буурч, олгосон тэтгэмжийн хэмжээ 40.6 (27.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2024 оны жилийн эцсийн байдлаар 61.0 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.6 (2.6%) мянган хүнээр буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 242.6 тэрбум төгрөг болж 44.8 (22.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 60.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 27.7 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 12.1 хувь нь ахмад настан, 0.2 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2024 оны жилийн эцсийн байдлаар 288.6 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 107.8 (59.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн халамжийн тэтгэмжид 149.7 мянган хүн хамрагдсаны 52.0 хувь нь асаргааны тэтгэмж, 48.0 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авсан иргэд байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД*, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар



* Урьдчилсан гүйцэтгэл
¹Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дүнд "Ирээдүйн өв сангийн тухай хууль"-ийн дагуу Сангийн яамнаас 2022 онд олгогдсон хүүхдийн мөнгөний зарцуулалтыг нэмж тусгасан.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хуульд заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий газар,
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 4 дүгээр сарын 15

Нийгмийн статистикийн
газрын дарга М.Оюунцэцэг
Утас : (976-51)-262903

Нийгмийн статистикийн газрын Нийгмийн
статистикийн хэлтсийн статистикч
У.Отгонзул
Утас : (976-51)-262325



/StatisticMGL



information@nso.mn



7014-1212